



Жендэрийн тэгш байдлын оролцоо судалгааны байгууллага мөн ШУТИМ (STEM) чиглэлд яагаад чухал вэ

**СЭДЭВ: “ЖЕНДЭРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТӨД ТУСГАХ НЬ”**

Хаана: Чойбалсан хот, Дорнод аймаг

ХэзээХугацаа: 2018 оны 12-р сарын 7-8-ны өдөр



Ц.Болормаа

Газарзүй геоэкологийн

хүрээлэн



Газарзүй геоэкологийн хүрээлэн





Жендэрийн асуудлыг байгууллагын хэмжээнд яагаад ярилцах хэрэгтэй вэ?

- Төрийн яамд, судалгааны байгууллагуудыг оролцуулаад ямар ч байгууллага жендэрийн хувьд саармаг БИШ юм.
- Жендэрийн асуудал нь заримдаа **ил харагддаг**, заримдаа **нуугдмал** байдаг.
- Жендэрийн эрх тэгш байдал зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал биш юм.
- Ажлын байран дээрх жендэрийн эрх тэгш байдал нь эдийн засгийн ерөнхий үзүүлэлттэй шууд холбоотой.
 - Үндэсний эдийн засгийн өсөлт илүү болно.
 - Бүтээмж өснө.
 - Өндөр чадвартай ажил горилогчдын хандалт ихэсдэг.
 - Байгууллагын ерөнхий гүйцэтгэл сайжирдаг.
- Жендэрийн талаар мэдлэг, ойлголттой байх нь **илүү чанартай ажлын үр дүн гаргах, илүү чанартай судалгаа** хийхэд хөтлөдөг.



Ажлын байран дээрх жендэрийн эрх тэгш байдал

Ажлын байран дээрх жендэрийн эрх тэгш байдал гэж хүйсээсээ ҮЛ ХАМААРАН БҮХ ажиллагсад тэгш боломжтой, тэгш эрхтэй, баялагаас адил тэгш хүртэнэ гэсэн утгатай.

Эмэгтэй, эрэгтэй хүмүүс:

- ажилд орох, тушаал дэвших тэгш боломжтой байх
- ажлын байран дээрээ аюулгүй бөгөөд хүндлэгдэж байх
- нөөцийн хувьд итгэл хүлээлгэдэг байх, хэрэгцээтэй арга хэрэгслээ олж авах боломжтой байх
- шийдвэр гаргахад оролцохыг асуудаг байх хэрэгтэй.

Эмэгтэй, эрэгтэй хүмүүс яг ижилхэн гэсэн **ҮГ БИШ**. Олон ялгаа байгаа. **ГЭХДЭЭ** тэдгээр ялгаа нь дээр жагсаасан зүйлсэд нөлөөлөхгүй байх ёстой.

ЖЕНДЭР БА БАЙГАЛЬ ОРЧИН

ЖЕНДЭР ГЭЖ ЮУ ВЭ?

Эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлага юм.

ЯАГААД ЖЕНДЭР НЬ БАЙГАЛЬ ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ ВЭ?


Байгаль орчинд нөлөөлөх томоохон хэсгүүдийн нэг нь хүний үйл ажиллагаа юм. Тийм учраас байгаль орчин нь жендэр зэрэг нийгмийн хүчин зүйлсийн нөлөөнд оршдог.

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгмийн үүрэг оролцоо, хариуцлага, мэдлэг, туршлагаас хамаарч байгаль орчинтой харьцах байдал нь өөр өөр байдаг:



Эрэгтэй, эмэгтэй хүмүүс байгалийн нөөцийг өөрсдийн хэрэгцээ шаардлагаас хамааран өөр өөрөөр ашигладаг.

"Судалгаагаар эрэгтэйчүүд усыг мал услах, аж ахуй эрхлэхэд түлхүү ашиглаж байгаа бол эмэгтэйчүүд хоол унд бэлтгэх, ахуйн хэрэглээнд түлхүү ашигладаг байна."



Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн байгаль орчин болон байгалийн нөөцийн талаарх мэдлэг харилцан адилгүй байдаг.

"Монголын хууль бус алт олборлогчид, бичил уурхай эрхлэгчид дунд хийсэн судалгаанаас үзэхэд: эмэгтэй хүмүүс гар аргаар алт угаах болон хоол хүнс бэлдэх зэрэг гарын дор ажилд илүү оролцдог бол эрэгтэй хүмүүс уурхайд олборлолт хийх нь түгээмэл байна. Үүнтэй холбоотойгоор эмэгтэйчүүд ерөнхийдөө усны бохирдлын талаар илүү мэдлэгтэй байдаг."



Дээрх ялгаатай түвшний мэдлэг, үүрэг хариуцлагаас болоод байгаль орчныг хамгаалах болон түүний тогтвортой байдлыг хангахад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оруулах хувь нэмэр өөр өөр байна.

"Эмэгтэйчүүд ихэвчлэн мод тарих, арчилж хамгаалах зэрэг үйл ажиллагаанд түлхүү оролцдог бол эрчүүд ихэвчлэн мод бэлтгэл зэрэг биеийн хүчний ажилд оролцдог."



Ийм учраас Олон улсад бүх түвшний бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгох хандлагатай байна.

Ялангуяа, байгаль орчны бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгох нь салбарын бодлого, хөтөлбөр, судалгааны ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд зогсохгүй өнөөгийн нийгэмд эерэг өөрчлөлтийг бий болгоход ихээхэн тустай юм.



Судалгааны байгууллагт жендэрийн асуудлыг яагаад ярих вэ?


ШУТИМ-ийн чиглэлийн судалгааны байгууллага, их сургуулийн төвшинд олон улсын хэмжээнд жендэрийг нэвтрүүлэх **3 зорилго** тавьсан

- ШУТИМ-ийн чиглэлийн эмэгтэй сурагчдын тоог магистр мөн докторын төвшинд нэмэгдүүлэх
- Шийдвэр гаргах төвшинд эмэгтэйчүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх
- Бүтээгдсэн мэдлэг ба инновацыг шинжлэх ухааныг сайжруулахад мөн нийгэмд ач холбогдол өгч уялдааг нь нэмэгдүүлэх





ШУТИМ дахь жендэрийн харьцаа, МЭДЭЭЛЭЛ





ШУТИМ дахь жендэрийн харьцаа, ОНЦЛОГ МЭДЭЭЛЭЛ

- Хөгжингүй оронд АНУ, Канад, Их Британи, Австрали, Франц, Дани, Португал гэх мэт сүүлийн жилүүдэд судлаачид шинийг санаачлагчдын дунд эмэгтэйчүүдийн хувь өссөн
- Эмэгтэйчүүдийн төлөөлөл амин зүй ба эрүүл мэндийн салбарын шинжлэх ухаанд илүү харин физикийн шинжлэх ухааны салбарт маш бага 25% эзэлдэг.
- Эмэгтэйчүүд эрчүүдийг бодвол шинжлэх ухаан, судалгааны өгүүлэл хэвлүүлэх нь бага байдаг. Гэвч үүнд ишлэл эсвэл татаж авах үзүүлэлтэнд нөлөөтэй үгүйг тодорхойлоогүй байна.
- Олон улсын төвшинд судалгааны өгүүлэл бичиж хамтарч ажиллах нь эмэгтэйчүүдийн хувьд эрчүүдийг бодвол харьцангуй бага.



ШУТИМ дахь жендэрийн харьцаа, онцлог мэдээлэл

- Мөн академик ба хувийн хэвшлийн хэмжээнд судалгааны чиглэлээр хамтран ажиллах нь эмэгтэйчүүдийн хувьд эрчүүдийг бодвол бага байдаг.
- Ерөнхийдөө, эмэгтэйчүүд эрчүүдийг бодвол нилээд салбар дундын хэмжээний судалгааны ажил хийдэг.
- Судлаачдын дунд эмэгтэй судлаач эрэгтэй судлаачыг бодвол олон улсын хэмжээнд ажиллах нь бага.
- Жендэрийн судалгаа нь цогц судалгааны хувьд хэмжээ нь томорч мөн цаг хугацааны хувьд тулгамдсан асуулын нэг болсоор байна. Өмнө нь АНУ-д жендэрийн асуудал нилээд яригддаг байсан одоо буурч харин Европын холбооны улсуудад ихээр яригдах болсон.



Figure 1.1 — Proportion and number of researchers by gender (among named and gendered author profiles) for each comparator and period, 1996–2000 vs. 2011–2015. Sources: Scopus, Genderize, NamSor, and Wikipedia




Figure 1.3 (continues next pages) — Proportion and number of researchers by gender (among named and gendered author profiles) for each comparator and subject area, 1996–2000 vs. 2011–2015. Sources: Scopus, Genderize, NamSor, and Wikipedia






Figure 1.4 — Scholarly output per researcher (among named and gendered author profiles), by gender for each comparator, 1996–2000 vs. 2011–2015.

Sources: Scopus, Genderize, NamSor, and Wikipedia



Figure 2.3 — Scholarly output resulting from international collaboration as share of total scholarly output by gender for each comparator, 1996–2000 vs. 2011–2015.

Sources: Scopus, Genderize, NamSor, and Wikipedia








Figure 2.5 — Top 10% of interdisciplinary scholarly output as share of total scholarly output by gender for each comparator, 1996–2000 vs. 2011–2015.
Sources: Scopus, Genderize, NamSor, and Wikipedia



Figures 2.6–2.9 (continues next page) — International mobility of researchers (among named and gendered author profiles) for the United Kingdom, Canada, Brazil, and Japan, 1996–2015.
Sources: Scopus, Genderize, NamSor, and Wikipedia





ШУТИМ дахь жендэрийн харьцааны зөрүүг бууруулах боломжит арга замууд

- Жендэрийн хэвшмэл ойлголт үзлийг өөрчлөх**
- Эмэгтэй үлгэр жишээг бий болгох**
- ШУТИМ төвт анги бүлгийн ажил төсөл хэрэгжүүлэх**
- ШУТИМ тэгш байдлын дүрэм журам гаргах**
- Бүх түвшний боловсролын байгууллагт сурталчилгаа, эерэг үзэл бодлыг нэвтрүүлэх**
- Грант ба тэтгэлэг өгөх**
- Бүх-Охид ШУТИМ байгууллагтай хамтрах**





Анхаарал тавьсанд
баярлалаа!

